



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.05.03 № 4-1/2160  
танай 2018.04.24 -ны № 05/1798 -Т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД  
Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Танайхаас ирүүлсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Журам батлах тухай” /Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам/ 49 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3893 дугаарт бүртгэснийг мэдэгдье.



Ц.НЯМДОРЖ



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2018 оны 05 сарын 03-ны  
өдрийн 38.93 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Авто замын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг баримтлан Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД

Ж.БАТЭРДЭНЭ



080187

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн  
49 дүгээр тушаалын хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ,  
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД АВАХ ЖУРАМ**

5919487  
1116126781

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, их засвар хийх инженерийн хийцтэй бүх төрлийн авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

**Хоёр. Авто зам, замын байгууламжийн  
барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох**

2.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд /цаашид Гүйцэтгэгч гэх/ нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын А хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналт тавих эрх бүхий Зөвлөх /цаашид Зөвлөх гэх/-өөр хянуулан Захиалагчид хүргүүлнэ.

2.2. Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ. Дурдсан хугацаанд хүсэлтийг шийдвэрлээгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг Гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлнэ.

2.3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухайн авто зам, замын байгууламж баригдаж дуусах хүртэлх гэрээнд заасан хугацаагаар олгоно. Барилгын ажил гэрээт хугацаанд дуусаагүйгээс гэрээний хугацаа сунгасан бол зөвшөөрлийн маягтад сунгасан тухай тэмдэглэнэ.

2.4. Зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд барилгын ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно. Энэ тохиолдолд Захиалагчид ажил эхлүүлэх хүсэлтийг дахин гаргаж шийдвэрлүүлнэ.

**Гурав. Авто зам, замын байгууламжийн  
барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох**

3.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил дараах шалтгаанаар 6 сараас дээш хугацаагаар зогссон бол барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлыг зогсоосон;
- Техник технологийн хяналтын Зөвлөхийн санал дүгнэлтэд үндэслэн Захиалагчийн шийдвэрээр ажлыг зогсоосон.

3.2. Дээрх үндэслэлээр барилгын ажил зогссон бол Гүйцэтгэгч энэхүү журмын 4 дүгээр хавсралтын Б хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, ажил зогсоосон шалтгаан, зөрчил дутагдлыг арилгасан тухай эрх бүхий байгууллагын дүгнэлтийн хамт ажил үргэлжлүүлэх


хүсэлтийг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч ирүүлсэн баримт бичгийг нягталж, шаардлага хангасан бол ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

#### **Дөрөв. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах**

- 4.1. Авто замын тухай хуулийн 28.1; 28.2-т заасан эрх бүхий байгууллага буюу Захиалагчийн зүгээс авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн /цаашид “Ажлын хэсэг” гэх/-ийг томилно.
- 4.2. Гүйцэтгэгч авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичиг, холбогдох материалыг бүрдүүлэн Зөвлөхөөр хянуулж, баталгаажуулна.
- 4.3. Захиалагч хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажлын хэсэг ажиллуулах эсэх шийдвэр гаргана. Захиалагч Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилохдоо авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран энэхүү журмын хоёрдугаар хавсралтыг удирдамж болгоно.
- 4.4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор ашиглалтад авах объектод очиж ажиллана.
- 4.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах Ажлын хэсгийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангуулах ажлыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, хяналтын Зөвлөх, Гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.
- 4.6. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хуралдаан зохион байгуулах, гишүүдийн ирц бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, гарах шийдвэрийн төсөл боловсруулах, техникийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан архивд хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.
- 4.7. Ажлын хэсэг томилсон шийдвэрийн дагуу газар дээр нь ажиллахаар товлосон өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө ажиллах газар, хугацаа, тухайн авто зам, замын байгууламжтай холбоотой ерөнхий мэдээллийг Ажлын хэсгийн нийт гишүүдэд хүргүүлсэн байна.
- 4.8. Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд энэ тухай Ажлын хэсгийн дарга болон нарийн бичгийн даргад газар дээр нь ажиллахаас 1-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэн байна.
- 4.9. Ажлын хэсгийн зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 4.10. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах тухай Ажлын хэсгийн дүгнэлт гарч, Акт үйлдэж баталгаажуулснаар уг авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулсанд тооцно.

#### **Тав. Ажлын хэсгийн эрх, үүрэг**

- 5.1. Ажлын хэсэг нь Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, стандарт, техникийн баримт бичигт заасан шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үүрэгтэй.
- 5.2. Ажлын хэсэг нийт гишүүдийн 90-ээс дээш хувийн ирц бүрдсэнээр ажиллана. Ажлын хэсгийн гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол тухайн гишүүнийг томилсон байгууллагаас орлон ажиллах хүнийг томилно.
- 5.3. Ажлын хэсгийн нийт гишүүдийн санал дүгнэлтийг үндэслэн, дийлэнх олонхийн саналаар эцсийн шийдвэр гаргана. Энэхүү шийдвэр нь “Авто замын тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.
- 5.4. Ажлын хэсгийн гишүүд мэргэжлийн чиглэл, ажлын чиг үүргийн дагуу ажиллаж, хариуцсан асуудал тус бүрээр санал дүгнэлтээ танилцуулна. Үүнд:
  - 5.4.1. Авто зам, замын байгууламжийг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх, гүйцэтгэлийн чанар, ашиглалтын болон



хөдөлгөөний аюулгүй байдал хангасан эсэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар нарийвчлан шалгах, дүгнэлт гаргах;

5.4.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, баталгаажуулалт хийсэн байдлыг шалгах, нягтлах;

5.4.3. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын хүрээнд хийгдсэн бусад байгууламж, төлбөр авах цэгийн барилга, суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн нэмэлт шугам сүлжээний ажилд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдал, стандартын шаардлага хангасан эсэх зэрэг ажил, үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгах, дүгнэх;

5.4.4. Зохих журмын дагуу үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх үнэлгээг гарган, ашиглалтад авах Ажлын хэсгийн акт, дүгнэлтэд тусгах;

5.5. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажил зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй буюу чанаргүй хийсэн, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн шаардлага зөрчсөн бол ашиглалтад авахыг тодорхой хугацаагаар хойшлуулна. Ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулна.

5.6. Авто замын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн заалтыг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Гүйцэтгэгч, Зөвлөх, зураг төслийн байгууллагад хариуцлага тооцох, тусгай зөвшөөрлийн эрх түдгэлзүүлэх, цуцлах зэрэг саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

5.7. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу хууль тогтоомж, стандарт, норм, норматив, дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг зөрчиж чанаргүй хийсэн, барилгын ажлын явцад Захиалагч болон Зөвлөх, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад авахаас татгалзана.

5.8. Ажлын хэсэг авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад авах, авто тээврийн хөдөлгөөн нээх шийдвэр гаргаж болно.

5.9. Ажлын хэсгийн зүгээс шаардлагатай гэж үзвэл авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн болон ашиглалтын шаардлага, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх талаар нарийвчилсан хэмжилт, иж бүрэн болон хэсэгчилсэн чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийлгэж болно.


5.10. Ажлын хэсгийн гишүүд зураг төсөл, техникийн шаардлагын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах талаар шаардлагатай үүрэг чиглэл өгч, гүйцэтгэлийн биелэлтийг хуралдаанд танилцуулан нэгдсэн зөвшилцөлд хүрсэн тохиолдолд энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулснаар Ажлын хэсгийн шийдвэр хүчин төгөлдөр болно.

5.11. Ажлын хэсгийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хурлын протоколд тэмдэглэж, Гүйцэтгэгч заасан хугацаанд чанартай гүйцэтгэж, биелэлтийг тайлагнах бөгөөд гүйцэтгэлийн чанарт Зөвлөх болон зам хариуцагч байгууллага хяналт тавьж ажиллана.

5.12. Ажлын хэсгийн акт баталгаажаагүй, архивын материалыг шаардлагын дагуу бүрдүүлж хүлээлгэж өгөөгүй байхад Гүйцэтгэгч болон Зөвлөхийн эцсийн шатны санхүүжилт олгохыг хориглоно.

### **Зургаа. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник технологийн хяналтын Зөвлөхийн эрх, үүрэг**

6.1. Зөвлөх нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил бүрэн дууссан тухай мэдэгдэл болон авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлтийг хянаж баталгаажуулан Захиалагчид хүргүүлнэ.



6.2. Барилгын ажлын үе шатны техник технологийн хяналтын болон Захиалагч, мэргэжлийн хяналтын байгууллагаас тавьсан албан шаардлага, Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Гүйцэтгэгчээр гаргуулж, хянаж баталгаажуулан Ажлын хэсэгт хүргүүлнэ.

6.3. Зөвлөх нь тухайн авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаанд тухайн объектын чанар байдалд гэрээнд заасны дагуу үзлэг хийж, дүгнэлт гаргаж, Захиалагчид ирүүлнэ.

6.4. Гүйцэтгэлийн чанар, технологийн алдаанаас үүссэн эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч засварлах үйл ажиллагаанд хяналт тавьж, чанарыг баталгаажуулна.

6.5. Авто зам, замын байгууламжийн ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс Ажлын хэсэг дахин ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

6.6. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн паспорт, картыг Ажлын хэсэг газар дээр нь ажиллахаас өмнө Гүйцэтгэгчээр гаргуулж, баталгаажуулсан байна.

### Долоо. Гүйцэтгэгчийн үүрэг

7.1. Авто зам, замын байгууламжийг зураг төсөл, стандарт, норм норматив, техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж, Ажлын хэсгийн дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгана.

7.2. Авто замын тухай хуулиар авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа 3 жил байхаар заасны дагуу Гүйцэтгэгч түүний чанарыг хариуцах, барилгын ажлын технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр засварлах баталгаа гаргаж, энэ хугацаанд гүйцэтгэх ажлын гэрээг Захиалагчтай байгуулж, хэрэгжүүлнэ.

7.3. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг, баримт бичгийн бүрдлийг бүрэн хангаж, батлагдсан маягтын дагуу замын паспорт, гүүр, хоолойн картыг үнэн зөв хөтөлж, цаасан болон цахим хэлбэрээр авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагын архивд хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

### Найм. Чанарын баталгаат хугацаа, барьцаа хөрөнгө суллах

8.1. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгаат хугацаанд Гүйцэтгэгч, Зөвлөх этгээдүүд тухайн зам, замын байгууламжид илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцна. Ашиглалтын буруугаас болон байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэлийг хариуцахгүй.

8.2. Баталгаат засварын хугацааг Захиалагч эсвэл ашиглалтад оруулах Ажлын хэсгийн дүгнэлт, шийдвэрээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нээсэн өдрөөс эхлэн тооцно.

8.3. Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад оруулсан тохиолдолд тухайн хэсэгт чанарын баталгаат хугацааг энэхүү журмын 8.2 дахь заалтын дагуу тооцно.


8.4. Чанарын баталгаат хугацаа дууссаны дараа дор дурдсан баримт бичгийг үндэслэн, Захиалагчийн албан ёсны зөвшөөрлөөр барьцаа хөрөнгийг суллана. Үүнд:

8.4.1. Баталгаат засварын хугацаанд хийгдсэн ажлын тайлан

8.4.2. Техник технологийн хяналтын Зөвлөхийн дүгнэлт

8.4.3. Зам хариуцагч байгууллагын зөвшөөрөл

8.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн акт баталгаажсанаар гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.



8.6. Ажлын хэсгийн акт баталгаажсанаар Зөвлөхийн болон Гүйцэтгэгчийн барьцаа хөрөнгийн 50 хувийг чөлөөлөх бөгөөд чанарын баталгаат хугацааны эхний 1 жилд уг объектод технологийн эвдрэл илрээгүй тохиолдолд үлдэгдэл барьцаа хөрөнгийн 50 хувийг чөлөөлнө. Чанарын баталгаат хугацаа дуусахад /акт баталгаажсанаас хойш 3 жил/ барьцаа хөрөнгийн үлдэгдлийг бүрэн чөлөөлнө.

#### Ес. Хүлээх хариуцлага


9.1. Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцад барилгын ажлын талаар худал мэдээлэл өгсөн талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үед гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн архивын материалын бүрдэлтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд бүрдэл дутуу материал архивд хүлээн авсан тохиолдолд тухайн мэргэжилтэн болон архивын ажилтанд хариуцлага тооцно.

9.3. Энэхүү журмыг зөрчсөн аливаа зөрчил нь Захиргааны, Эрүүгийн, Зөрчлийн тухай, Иргэний хуулийн заалтыг зөрчсөн эсэхийг Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх бүхий хууль хяналтын байгууллага тогтоож, холбогдох хуулийн заалтаар хариуцлага оногдуулна.

9.4. Барилга, байгууламжийг ашиглалтад авах Ажлын хэсгийн гишүүд хууль зөрчиж, алдаатай шийдвэр, дүгнэлтийг санаатай болон санамсаргүйгээр гаргасан нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авилгын эсрэг хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

-оОо-



“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил  
эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах  
журам”-ын нэгдүгээр хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ,  
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ**



20 ... оны ... сарын  
... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**1. Авто зам, замын байгууламж түүний туслах барилгуудын мэдээлэл:**

Авто зам, замын байгууламж, объектын нэр: .....  
Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/  
Зургийн шифр ..... Магадлалын дугаар .....  
Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр: .....  
Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: .....

**2. Газар олгосон шийдвэрийн мэдээлэл:**

Газар олгосон шийдвэрийн (захирамж): 20... оны ...сарын ... өдрийн ... дугаар  
Байршил: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/

**3. Гүйцэтгэгч байгууллагын талаарх мэдээлэл:**

Байгууллагын оноосон нэр: .....  
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....  
Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар: .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/  
Холбоо барих: ..... цахим хаяг, ..... утасны дугаар

**4. Захиалагч байгууллагын талаарх мэдээлэл:**

Байгууллагын оноосон нэр: .....  
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/  
Холбоо барих: ..... цахим хаяг, ..... утасны дугаар

**5. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгч байгууллагын  
талаарх мэдээлэл:**

Байгууллагын оноосон нэр: .....  
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....  
Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар: .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/  
Холбоо барих: ..... цахим хаяг, ..... утасны дугаар

**6. Зураг төсөл зохиогч байгууллагын талаарх мэдээлэл:**

Байгууллагын оноосон нэр: .....  
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....  
Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар: .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж  
Холбоо барих: ..... цахим хаяг, ..... утасны дугаар

10. Онцгойлон заах нөхцөл: .....



11. Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд: .....

12. Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл: .....

13. Зөвшөөрөл олгосон албан тушаалтны мэдээлэл:


..... байгууллагын нэр, ..... албан тушаал,  
..... овог нэр, ..... гарын үсэг,  
(тамга, тэмдэг)

### ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАЛТ

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

1. Зөвшөөрлийн хугацааг сунгах шалтгаан, үндэслэл: .....
2. Барилгын ажлын явцын мэдээлэл:  
Гүйцэтгэсэн ажлын үе шат, нэр, төрөл, хэмжээ .....
3. Зөвшөөрлийг сунгах хугацаа: .....
4. Онцгойлон заах нөхцөл: .....
5. Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд: .....
6. Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл: .....
7. Зөвшөөрөл сунгасан албан тушаалтны мэдээлэл:  
..... байгууллагын нэр, ..... албан тушаал,  
..... овог нэр, ..... гарын үсэг  
(тамга, тэмдэг)

----- оОо -----



“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил  
эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад  
авах журам”-ын хоёрдугаар хавсралт

УХА01382  
5919487  
11612678


**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД АВАХ АЖТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал	Ашиглалтад авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн		
		Дарга	Нарийн бичгийн дарга	Гишүүд
1	1. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламж 2. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж	Салбарын төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга	Салбарын төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтэн	<ol style="list-style-type: none"> <li>Захиалагчийн төлөөлөл</li> <li>Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл</li> <li>Техник технологийн хяналтын Зөвлөхийн төлөөлөл</li> <li>Авто замын бүртгэл мэдээллийн сан хариуцсан ажилтан</li> <li>Зам хариуцагч байгууллагын төлөөлөл</li> <li>Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл</li> <li>Замын цагдаагийн албаны төлөөлөл</li> <li>Салбарын мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</li> <li>Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл</li> <li>Орон нутгийн засаг захиргааны байгууллагын авто замын асуудал хариуцсан ажилтан</li> </ol> <p>/Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./</p>

Ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн		
№	Дарга	Нарийн бичгийн дарга
2	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал  Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа авто замын асуудал эрхэлсэн агентлагийн холбогдох газар, хэлтсийн дарга
		<p>1. Захиалагчийн төлөөлөл</p> <p>2. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл</p> <p>3. Техник технологийн хяналтын Зөвлөхийн төлөөлөл</p> <p>4. Орон нутгийн захиргааны байгууллагын авто замын бүртгэл мэдээллийн сан хариуцсан ажилтан</p> <p>5. Зам хариуцагч байгууллагын төлөөлөл</p> <p>6. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл</p> <p>7. Аймаг, нийслэлийн замын цагдаагийн албаны төлөөлөл</p> <p>8. Аймаг, нийслэлийн салбарын мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</p> <p>9. Мэргэжлийн хяналтын байгууллагын эрчим хүч, харилцаа холбоо, барилгын техникийн хяналтын байцаагч /Гухайн чиглэлийн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн тохиолдолд/</p> <p>10. Онцгой байдлын газрын төлөөлөл (шаардлагатай тохиолдолд)</p> <p>11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл</p> <p>/Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./</p>



Ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн				
№	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал			
Дарга	Нарийн бичгийн дарга			
Гишүүд				
3	<p>Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж</p>	<p>Захиалагч байгууллага</p>	<p>Захиалагч байгууллага</p>	<p>1. Захиалагчийн төлөөлөл  2. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл  3. Техник технологийн хяналтын Зөвлөхийн төлөөлөл  4. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл  5. Аймаг, нийслэлийн замын цагдаагийн албаны төлөөлөл  6. Аймаг, нийслэлийн салбарын мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл  7. Мэргэжлийн хяналтын байгууллагын эрчим хүч, харилцаа холбоо, барилгын техникийн хяналтын байцаагч /Тухайн чиглэлийн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн тохиолдолд/  /Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран бусад байгууллагаас нэмж төлөөлөл томилж болно./</p>



“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын гуравдугаар хавсралт



**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН АКТ, ДҮГНЭЛТ**

20 ... оны ... сарын ... Дугаар ... Улаанбаатар хот  
... -ны өдөр

**НЭГ. Ерөнхий мэдээлэл**

- 1.1. Авто зам, замын байгууламж, объектын нэр: .....  
Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц .....  
Зургийн шифр ..... Магадлалын дугаар .....  
Хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/
- 1.2. Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: .....  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....
- 1.3. Туслан гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: .....  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....
- 1.4. Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр: .....  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....
- 1.5. Захиалагч байгууллагын нэр, хаяг: .....  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....
- 1.6. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг: .....  
.....  
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....
- 1.7 .....  
шийдвэрээр зохион байгуулсан хүний ..... бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай ..... байгууллагын 20 ... оны ... сарын ... -ны өдрийн ..... дугаар мэдэгдлийн дагуу 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс ...-ны өдрүүдэд шинээр барьсан /их засвар, өргөтгөл/ шинэчлэлтийн ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.
- 1.8. Энэхүү ..... авто зам, замын байгууламжийг ..... шифртэй зураг төслөөр ..... оны ..... сараас барьж эхэлсэн бөгөөд ..... оны ..... сарын ..... -ны өдөр барьж дуусгасан байна.



## ГУРАВ. Актын баталгаажуулалт

.....  
(Тухайн авто зам, замын байгууламжийн нэр, байршил, хүчин чадал)-г ашиглалтад авах дүгнэлт гаргасан:

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:


Ажлын хэсгийн дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар: Энэхүү хуудсанд Ажлын хэсэгт ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ дээр нь тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

----- оОо -----



“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын дөрөвдүгээр хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН АШИГЛАЛТАД АВАХАД БҮРДҮҮЛСЭН БАЙХ ШААРДЛАГАТАЙ БИЧИГ, БАРИМТЫН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх бичиг, баримт
<u>А. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт</u>	
1.	Гүйцэтгэгч байгууллагын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг
2.	Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн болон авто зам, замын байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3.	Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
4.	Улаан шугам хүлээлцсэн акт
3.	Магадлал хийгдсэн тухайн авто зам, замын байгууламжийн иж бүрэн зураг төсөл, Экспертизийн дүгнэлт
4.	Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн техник, технологийн хяналт гүйцэтгэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ
5.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, техникийн нөхцөлүүд
6.	Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий байдлын үнэлгээ, шаардлагатай бол байгаль орчин нөлөөлөх байдлыг албажуулсан нарийвчилсан үнэлгээ
7.	Археологи, палеонтологийн тандалт, судалгааны тайлан /зураг төслийн шатанд хийгдсэн тохиолдолд/
<u>Б. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт</u>	
1.	Ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Гүйцэтгэгчийн албан хүсэлт
2.	Ажил зогсоох шийдвэр гаргасан холбогдох эрх бүхий байгууллагын ажил үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр, дүгнэлт
3.	Зөрчил арилсан тухай баримт, хийсэн ажлын тайлан
<u>В. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авахад бүрдүүлэх, архивт хүлээлгэн өгөх бичиг, баримт</u>	
1.	Захиалагчтай байгуулсан гэрээ /эх хувь/, нэмэлт гэрээ
2.	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл
3.	“Авто замын тухай” хуулийн 4.1.18.-д заасан зураг төслийн иж бүрдэл /эх хувь/
4.	Улаан шугам хүлээлцсэн акт
5.	Ашиглалтад авах Ажлын хэсэг ажиллуулах хүсэлт гаргасан албан бичиг, Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, баталгаажсан акт, гишүүдийн саналын хуудас
6.	Гэрээ дүгнэсэн акт /эх хувь/
7.	Санхүүжилтийн гүйцэтгэл /тооцоо нийлсэн акт
8.	Гүйцэтгэлийн зураг
9.	Авто зам, замын байгууламжийн зурвас газрын кадастрын зураг



10.	Археологи, палеонтологийн авран хамгаалах ажлын тайлан /эх хувь/
11.	Геодезийн хэмжилтийн материал
12.	Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд
13.	Засаг даргын газар олгосон захирамж, карьеруудыг нөхөн сэргээсэн акт /байгаль орчны улсын байцаагчийн гарын үсэгтэй/
14.	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан /эх хувь/
15.	Замын бүртгэл мэдээллийн паспорт, гүүр, хоолойн карт /цаасан болон цахим хэлбэрээр/ 4%
16.	Зөвлөх багийн эхлэлийн, явцын, эцсийн шатны тайлан, шаардлага, дүгнэлт, түүний биелэлт, Голлон ажилласан замын инженер, техникийн ажилтнуудын анкет, Зөвшөөрөл авах хүсэлтүүд, Гэрэл зургийн цомог, Ирсэн болон явуулсан албан бичиг, хурлын тэмдэглэлүүд, талбайн уулзалтын тэмдэглэл /он сарын дарааллаар/
17.	Тухайн барилга, байгууламжид чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийгдсэн тохиолдолд судалгааны баталгаажуулсан дүгнэлт /Журмын 6.9 заалт/ (замын тэгш байдлын үзүүлэлт, хучилтын бат бэх, гадаргуугийн гулсалтын эсэргүүцэл, гадаргуугийн дугуй мөрний хотойлт, гадаргуугийн барзгаржилт, далан суурийн даац, хурдны хангалт г.м)

-оОо-

